



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 30 өдөр

Дугаар

А/
1223

Улаанбаатар хот

Илрүүлэг, шинжилгээг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Журам батлах тухай” 11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээнд 40-65 насны иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааны уялдааг хангах гурван талт “Хамтран ажиллах гэрээний загвар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээнд иргэдийг хамруулах ажлыг дор дурдсан байдлаар шуурхай зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгосугай. Үүнд:

2.1. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан гэрээний загварын дагуу нэг талаас аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, нөгөө талаас аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, гурав дахь талаас өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүд гэрээ байгуулах;

2.2. Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г үндэслэн элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээний сорьц зөөвөрлөх, сорьцыг хүлээн авч, төвлөрүүлэн хадгалахад шаардлагатай зарим санхүүжилтийн болон техникийн туслалцаа авах талаар харьяа нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг даргад хандан асуудлыг шийдвэрлэж, санаачлагатай ажиллах.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/, Эм үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/, Бодлого, төлөвлөлтийн газар /Д.Төмөртогтоо/-т тус тус үүрэг болгосугай.

080719

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн Дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 05 сарын 30-ны өдрийн
А/ дугаар тушаалын хавсралт
223



БАТЛАВ.

.....
АЙМАГ/ НИЙСЛЭЛИЙН

.....
АЙМАГ/ ДҮҮРГИЙН

.....
ӨРХ/ СУМ, ТОСГОНЫ

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА

ЭМТ, НЭ / БОЭТ-ИЙН
ДАРГА

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны 05 сарын өдөр

№

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээ (цаашид “илрүүлэг, шинжилгээ” гэх)-нд 40-65 насны иргэдийг хамруулахад орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, илрүүлэг, шинжилгээг чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлэх нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг хангах зорилгоор нэг талаасаймаг/ нийслэлийн Эрүүл мэндийн газрыг төлөөлж
....., аймаг/ дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, БОЭТ-ийг төлөөлж
....., өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг төлөөлж..... нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

2.1. Энэхүү гэрээ нь “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд илрүүлэг, шинжилгээнд 40-65 насны иргэдийг бүрэн хамруулахад орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, илрүүлэг, шинжилгээг чанартай, чирэгдэлгүй үзүүлэх нэгдсэн зохион байгуулалтыг хангахад оршино.

2.2. Талууд гэрээний зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын “Эрүүл мэндийн тухай”, “Эрүүл мэндийн даатгалын тухай”, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо,

шинжилгээнд хамруулах журам” 2017 оны 11 дүгээр тогтоол, Хөдөрмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Даатгуулагчийг элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээнд хамруулах, даатгалын сангаас зардлын төлбөрийг санхүүжүүлэх журам” 2017 оны А/94, А/193, Эрүүл мэндийн сайдын “Шинжилгээний сорьц зөөвөрлөх журам” 2016 оны А/93, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварыг бүртгэх, мэдээлэх журам” 2014 оны 186, “Заавар батлах тухай” 2014 оны 187 дугаар тушаал, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 70 дугаар тушаалаар батлагдсан “Био аюултай илгээмж, био бэлдмэлийг тээвэрлэх журам”-ыг тус тус баримтлан ажиллана.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Харьяа нутаг дэвсгэрийн 40-65 насны иргэдийг илрүүлэг, шинжилгээнд хамруулах ажлын төлөвлөгөөг батлан, үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

3.2. Илрүүлэг, шинжилгээний багц, сорьц цуглуулах, зөөвөрлөх, хадгалахад шаардлагатай багаж, хэрэгсэл болон илрүүлэг, шинжилгээнд хамрагдах иргэдийн бүртгэл, мэдээллийн программын хэрэглэгчдийн бэлэн байдлыг тус тус хангана.

3.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн харьяа нутаг дэвсгэрийн 40-65 насны иргэдэд илрүүлэг, шинжилгээ хийх хуваарь гаргаж ажлын ачааллыг зохицуулах, хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр зохион байгуулахад удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд илрүүлэг, шинжилгээ хийх боломжгүй тохиолдолд зэргэлдээ өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв эсхүл нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төвийг дайчлан ажиллуулахаар зохион байгуулна.

3.5. Илрүүлэг, шинжилгээ хийхэд энэхүү гэрээний 2.2-т заасан дагаж мөрдвөл зохих заавар, журмыг танилцуулах сургалтыг эмч, мэргэжилтнүүдэд шуурхай зохион байгуулна.

3.6. Илрүүлэг, шинжилгээнд иргэдийн хамрагдалтыг идэвхжүүлэх зорилгоор мэдээлэл, сурталчилгааны ажлыг удирдан зохион байгуулна.

3.7. Илрүүлэг, шинжилгээнд хамрагдсан 40-65 насны иргэдийн бүртгэл, мэдээллийн хөтлөлтөд хяналт тавьж, тайлан, мэдээг товлосон хугацаанд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн статистик мэдээллийн албанд мэдээлнэ.

3.8. Илрүүлэг, шинжилгээг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор болзолт уралдаан зарлаж, дүгнэх, идэвхтэй ажилласан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, салбар амбулатори, эмч, мэргэжилтнийг урамшуулах ажлыг нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулна.

3.9. Илрүүлэг, шинжилгээний хамралт, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт, зарцуулалтад байнгын хяналт тавьж ажиллана.

3.10. Илрүүлэг шинжилгээг хийх, шинжилгээний сорьц зөөвөрлөх, хадгалахтай холбоотой санхүүжилтын болон техникийн туслалцаа авах талаар

харьяа нутаг дэвсгэрийн Засаг даргатай зөвшилцөн, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж ажиллана.

ДӨРӨВ. ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Илрүүлэг, шинжилгээний багцын худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба (Эрүүл мэндийн газар)- тай хамтран зохион байгуулж, хангана.

4.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд илрүүлэг, шинжилгээг хийх боломжгүй тохиолдолд нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, салбар амбулатори гүйцэтгэнэ.

4.3. Энэхүү гэрээний 2.2-т заасан заавар журмын дагуу илрүүлэг, шинжилгээ хийх, сорьц цуглуулах, дугаарлах, хадгалах, зөөвөрлөх болон халдвар хамгааллын заавар, журам, сорьц тээвэрлэлтийн чанар, аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр мэргэжил, арга зүйн сургалтыг Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулна.

4.4. Илрүүлэг, шинжилгээний бүртгэл, мэдээллийн программын бэлэн байдлыг ханган, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс илрүүлэг, шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн шинжилгээний хуудасны нэг хувийг хүлээн авч нэгтгэнэ.

4.5 Илрүүлэг, шинжилгээнд хамрагдсан даатгуулагчдын нэрсийн жагсаалт, нэхэмжлэлийг харилцагч Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэн санхүүжилтийг гүйцэтгэлээр хүлээн авна.

4.6. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдээс илрүүлэг, шинжилгээний сорьцыг хүлээн авч, төвлөрүүлэн хадгална.

4.7. Элэгний В, С вирус эерэг гарсан сорьцыг В, С вирусын идэвхжил тодорхойлохоор сонгогдсон лабораторитой гэрээ хийж шинжлүүлнэ.

ТАВ. ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь харьяа нутаг дэвсгэрийн 40-65 насны эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн иргэдийг вэб-д суурилсан elegbuten.mohs.mn программд бүртгэж, илрүүлэг, шинжилгээнд хуваарийн дагуу хамруулах ажлыг урьдчилан зохион байгуулж гүйцэтгэнэ.

5.2. Эрүүл мэндийн даатгалгүй 40-65 насны иргэдийг сум, баг, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, халамжийн байгууллагын дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулж, илрүүлэг шинжилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

5.3. Илрүүлэг, шинжилгээг хариуцан зохион байгуулах эмч, мэргэжилтнийг томилж, илрүүлэг, шинжилгээний багц, илрүүлэг хийх, сорьц хадгалах, зөөвөрлөх ажиллагааны бэлэн байдлыг хангана.

5.4. Энэхүү гэрээний 2.2-т заасан заавар, журмын дагуу илрүүлэг, шинжилгээ хийх, сорьц цуглуулах, дугаарлах, хадгалах, зөөвөрлөхөд халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, сорьц тээвэрлэлтийн чанар, аюулгүй байдлыг

ханган, сорьцыг нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, салбар амбулаторийн лабораторид хүлээлгэн өгнө.

5.5 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/94, А/193 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Даатгуулагчийн элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээний хуудас”-ыг хөтөлж, 2 хувь гарган нэгийг нь иргэнд өгч, үлдсэн хувийг нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төвийн статистикийн мэдээллийн албан (эрүүл мэндийн даатгал хариуцсан эмч, ажилтан)-д хүргүүлнэ.

5.6 Харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг илрүүлэг, шинжилгээнд бүрэн хамруулах, түүний ач холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгааг сум, баг, хорооны нийгмийн ажилтан, сайн дурын идэвхтний оролцоотойгоор хамтран зохион байгуулна.

5.7. Илрүүлэг шинжилгээг хийх, шинжилгээний сорьц зөөвөрлөх, хадгалахад тулгамдсан асуудлыг сум, хороо, багийн Засаг даргатай зөвшилцөн, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж ажиллана.

ЗУРГАА. УДИРДЛАГА, ХЯНАЛТ

6.1 Энэхүү гэрээний зорилгыг амжилттай хэрэгжүүлэх үүднээс талууд хүлээсэн үүргээ биелүүлж, илрүүлэг, шинжилгээний явцад байнгын хяналт тавьж, тулгамдсан асуудлыг өөрийн нөөц бололцоог дайчлан шийдвэрлэж ажиллана.

6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ажлын тайланг долоо хоног бүр гаргаж, харилцан тайлагнаж, мэдээлэл солилцоно.

6.3 Гэрээний талууд тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Эрүүл мэндийн яам, харьяа Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагатай зөвшилцөн хамтран шийдвэрлэнэ.

6.4 Энэхүү гэрээ нь 20.... оны сарын ны өдрөөс 20..... оны сарын өдөр хүртэл хугацаанд хүчинтэй.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛС

7.1 Гэрээний хугацаанд ажил гүйцэтгээгүй болон тухайн үед аль нэг талаас шалтгаалан ажил зогссон тохиолдолд буруутай тал хариуцлагыг хүлээнэ.

7.2 Энэхүү гэрээтэй холбоотойгоор гарч болзошгүй санал зөрөлдөөнийг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

НАЙМ. ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

.....
АЙМАГ/ НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР

.....
АЙМАГ/ ДҮҮРГИЙН
ЭМТ, НЭ / БОЭТ

.....
ӨЭМТ, СЭМТ, ТЭМТ
СУМ ДУНДЫН
ЭМНЭЛЭГ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Талууд энэхүү гэрээний бүхий л нөхцөл, заалтыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон гарын үсэг зурж, баталгаажуулан тус бүр 2 хувь үйлдэнэ.

.....
Аймаг/ нийслэлийн
Эрүүл мэндийн
газрыг төлөөлж

.....

.....
Аймаг/ дүүргийн
ЭМТ, НЭ / БОЭТ-ийг
төлөөлж

.....

.....
ӨЭМТ, СЭМТ, ТЭМТ
Сум дундын эмнэлгийг
төлөөлж

.....